



БАЯНГОЛ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30 № 67А-2020/04-НА-22  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Баянгол сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Баянгол сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

• 018020583


## Дүгнэлт

Баянгол сумын Ардчилсан намын хорооны Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр  
1..9... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



## ӨРХИЙН ӨСӨЛТӨӨС СУМЫН ХӨГЖИЛ

### СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

#### УРИА: ӨРХИЙН ӨСӨЛТӨӨС СУМЫН ХӨГЖИЛ

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд:

Сэлэнгэ аймгийн иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд “ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.



НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ



1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх “СЭЛЭНГЭ STEAM” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/
- 1.1.3 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн тогтвортой, улс төрөөс хараат бус байх тал дээр төрийн албаны тухай хуулийг чандлан баримтлан ажиллана.
- 1.1.4 Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэд, иргэдэд дохионы хэлний сургалтыг төрийн бус байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулж ажиллах.
- 1.1.5 Багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, давтан сургаж, “Шинэ Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Сумын ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаадын түнш орнуудтай хамтарч ажиллана.
- 1.1.7 Сумын хүүхэд залуучуудыг Англи хэлний боловсрол олгох сургалтад хамруулна.
- 1.1.8 Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.1.9 Иргэдийн цахим боловсролыг дэмжих төвүүдийг байгуулахад бодлогоор дэмжинэ.

1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1 Сумын иргэдийн дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөл эндэгдлийн шалтгаанд суурилсан эрт илрүүлэгийн үзлэгийг зохион байгуулж, эмчилгээ, хяналтын чанарыг сайжруулан, өвчлөлийг бууруулна.
- 1.2.2 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 1.2.3 Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, өвчлөл, эндэгдлийг бууруулан ажиллана.
- 1.2.4 Сумын хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний бүтэц зохион байгуулалт, төлөвлөлттэй уялдуулан хүний нөөц бэлтгэх, сургах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.5 Эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээнд цахим эрүүл мэнд болон шинэ дэвшилтэт арга технологи нэвтрүүлнэ.
- 1.2.6 Сумын эрүүл мэндийн төвд чанарын ISO 9001-2015 стандарт, олон улсад хүлээн зөвшөөрсөн чанарын удирдлагын бусад дэвшилтэт арга барилыг нэвтрүүлнэ.
- 1.2.7 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эрүүл мэндийн байгууллага бий болгохоор уламжлан ажиллах.
- 1.2.8 Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг эрчимжүүлж, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн “Эрүүл мэндийг дэмжих” жижиг төвүүд ажиллуулах боломжийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.
- 1.2.9 Сумын хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх гөрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт



сурталчилгааг зохион байгуулах үйл ажиллагаанд бусад аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагааг дэмжинэ.

1.2.10 Сумын эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.

1.2.11 Сумын хүн амын дунд эрүүл мэндийн даатгалын цахим картгыг нэвтрүүлнэ.



### 1.3. Хүн амын өсөлт, хөгжил

1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж дэмжиж ажиллана.

1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах орон нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3.3 Сумын төвд хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.3.4 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3.5 Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүл, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлж, өрх толгойлсон эх /ганц бие эцэг/, хүүхдийг эрсдэлээс хамгаалах нөхцөлийг сайжруулна.

1.3.6 Сумын байгууллагуудын хүний нөөцийн цогц бодлого, чадварт суурилсан мерит зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжтой салбарын хүний нөөцийн жендерийн тэгш байдлыг хангах, суманд суурьшин ажиллах боловсон хүчнийг орон байраар хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг авч ажиллана.

### 1.4. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт

1.4.1 Сумын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.4.2 Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрнө.

1.4.3 Орон нутагт гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлнэ.

1.4.4 Өдөр өнжүүлэх төвийн санаа санаачилга гаргасан иргэн, аж ахуй нэгж байгууллагыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай дэмжиж ажиллана.

### 1.5. Нийгмийн хамгаалал

1.5.1 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлж, халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлнэ.

1.5.2 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.

1.5.3 Нийгмийн халамжийн салбарт сайн дурын даатгалын ажлыг дэмжиж ажиллана.

1.5.4 Иргэд, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангахад бодлогоор дэмжин ажиллана.

### 1.6. Соёл, урлаг, спорт

1.6.1 Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртгээл болгох ажлыг эхлүүлнэ.

1.6.2 Сумын соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.



- 1.6.3 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.
- 1.6.4 Мэргэжлийн урлагийн байгууллага, залуу уран бүтээлчдийн уран бүтээлээ олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд дээд шатны байгууллагад уламжлан дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.5 Сайн дурын уран сайханчид урлагийн холбоонд элсэхэд түүнийг уламжлан дэмжин ажиллана.
- 1.6.6 Түүх, соёлын агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.
- 1.6.7 Сумын биеийн тамир, спортын салбарт аюулгүй ажиллагааны талаар шаардлагатай стандартуудыг нэвтрүүлж ажиллана.
- 1.6.8 Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулна.
- 1.6.9 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6.10 Их спортыг дэмжин, спорт клубийг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.
- 1.6.11 Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.6.12 Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгээр хөл бөмбөгийн орчин үеийн шийдэл, стандартад нийцсэн талбай барьж ашиглалтад оруулна.



## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. Хямралыг боломж, боломжийг өсөлт

- 2.1.1 Сумын төсвийн зарлагын тэвчиж болох зардлыг хязгаарлана.
- 2.1.2 Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, цахилгаан, дулаан, цэвэр усаар хангагч байгууллагуудын тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрдүүлнэ.
- 2.1.3 Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дотоод орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг өргөнөөр хэрэглэх журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.1.4 Сумын хэмжээнд “Таниас худалдан авъя” хөдөлгөөнийг өрнүүлж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ.
- 2.1.5 Үр тариа, төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд борлуулахад дэмжиж ажиллана.
- 2.1.6 Мал амьтны өвөлжилтөд онцгой анхаарч өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэн боломжит тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
- 2.1.7 Эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын тогтвортой ажиллах нөхцөл боломжийг хангаж ажиллана.

### 2.2. Өсөлтийн бодлого

- 2.2.1 Орон нутагт ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн 80-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг санаачилсан гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

### 2.3. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа

- 2.3.1 Баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийг бодлогын хүрээнд дэмжиж ажиллана.
- 2.3.2 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжинэ.
- 2.3.3 Бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг үйлчилгээг бий болгоно.



#### 2.4. Төсөв, санхүү, татварын бодлого

- 2.4.1 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.
- 2.4.2 Хуримтлалыг бий болгох сургалт мэдээллийн бодлогыг хэрэгжүүлж иргэдийн банкин дахь хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.4.3 Татварын байцаагч, иргэд, аж ахуй нэгж байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлд шинэчлэлийг хийнэ.



#### 2.5. Хөдөлмөрийн зах зээл

- 2.5.1 Эрдэс баялаг, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.5.2 Суманд жуулчид хүлээн авах хүчин чадлыг бий болгох, аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ.
- 2.5.3 Мэргэжилтэй ажиллах хүчин, дээд боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургууль төгсөгчдийг үе шаттайгаар хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор суманд хүний нөөцийн сан бүрдүүлж ажиллана.

#### 2.6. Үйлдвэрлэл

- 2.6.1 Сумын төвийг дайран өнгөрч буй олон улсын зам дагуу аж үйлдвэрийн парк байгуулах иргэн, аж ахуй нэгж байгууллагыг дэмжин ажиллана.
- 2.6.2 Орон нутагтаа стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох жимс жимсгэнэ, элсэн чихэр, ургамлын тосны хангамжийг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.
- 2.6.3 Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулж ажиллана.
- 2.6.4 Төв суурин газрын нийтийн орон сууцны оршин суугчдад хүнсний хэрэгцээгээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн улирлын төвлөрсөн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжиж, ногоо тариалах газрын асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 2.6.5 Малаас гарч буй түүхий эд болсх арьс шир үйлдвэрлэгч жижиг дунд эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 2.6.6 Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гадны байгууллагуудын хөрөнгө оруулалт, зээл, тусламжид хамруулах бодлогыг холбогдох байгууллагад өргөн мэдүүлж, хамтран ажиллана.
- 2.6.7 Сумын брэнд болсон бүтээгдэхүүнийг төрийн бүх байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож, бүтээгдэхүүн худалдан авах, худалдаалах боломжийг дэмжин ажиллана.


#### 2.7. Дэд бүтэц, барилга

- 2.7.1 Эдийн засгийн өсөлтийн суурь болсон хатуу болон зөөлөн дэд бүтэц (зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо)-ийн хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн, болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг идэвхтэй ашиглана.
- 2.7.2 Сайн хашаа хөтөлбөрийг үргэлжлүүлэн, авто замын уулзварыг шинэчлэх талаар холбогдох мэргэжлийн байгууллага болон Засгийн газарт уламжлах.
- 2.7.3 Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулна.
- 2.7.4 Сайн өвөлжөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн ажиллана.



## 2.8. Барилгын салбар

- 2.8.1 Барилга, байгууламжийн насжилтыг тогтоож мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, дахин төлөвлөх ажлыг орон нутагт зохион байгуулж ажиллана.
- 2.8.2 Сумын барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг мөрдүүлнэ.
- 2.8.3 Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам шат бүхий хэрэгслийг мэргэжлийн байгууллагуудын саналыг авч холбогдох газарт уламжлах.



## 2.9. Эрдэс баялгийн салбар

- 2.9.1 Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгоно.
- 2.9.2 Сумын нутаг дэвсгэрт нөхөн сэргээх шаардлагатай газруудад нөхөн сэргээх үйл ажиллагааг нь санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, иргэд, аж ахуй нэгж, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээж ажиллана.

## 2.10. Аялал жуулчлал

- 2.10.1 Спортын, эрүүл мэндийн, эко-туризм, ургамал, амьтан судлал, түүх соёлын дурсгалт газруудын судалгаа шинжилгээ экстрим /адал явдалт/ аялал зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.
- 2.10.2 Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.10.3 Аялал жуулчлалын салбарт ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлнэ.
- 2.10.4 Суманд жуулчилж, аялах эрэлтийг нэмэгдүүлэх, эргэлтийг нь сайжруулах зорилгоор эвент арга хэмжээг зохион байгуулна.

## 2.11. Шинжлэх ухаан технологи, мэдээлэл, харилцаа

- 2.11.1 Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ.
- 2.11.2 Айл өрхийн хаягжилтыг сайжруулан шуудан хүргэлтийн системийг боловсронгуй болгох ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.11.3 Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.11.4 Иргэдэд зориулсан цахим боловсролын төвүүдийг байгуулна.

## 2.12. Эрчим хүч

- 2.12.1 Сумын цахилгаан эрчим хүчний хоёрдогч эх үүсвэрээр хангах асуудлыг мэргэжлийн байгууллагуудаар судлуулж уламжлан шийдвэрлүүлэх.
- 2.12.2 Сумын халаалтын төв, шугам сүлжээг шинэчлэх, хүчин чадлыг сайжруулах ажлыг аймгаас гарсан Улсын Их Хурлын гишүүнээр дамжуулан улсын төсөвт холбогдох зардлуудыг суулгуулах.
- 2.12.3 Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.





**ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ**

**3.1. Орон нутгийн хөгжил**

- 3.1.1 Орон нутгийн төрийн худалдан авалтын үйл ажиллагааг сумандаа сонгон шалгаруулдаг, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг, шалгарсан байгууллагууд тухайн орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах бодлогыг баримтална.
- 3.1.2 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг бодлогоор дэмжинэ.
- 3.1.3 Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийний аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлнэ.



**3.2. “Шинэ хөдөө” хөтөлбөр**

- 3.2.1 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хүлэмжээр хангаж, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.2.2 Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн сум болгон хөгжүүлэх ажлыг Засгийн газарт уламжлан ажиллана.

**3.3. Бэлчээр ашиглалт**

- 3.3.1 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан сумын газар нутгийн 20 орчим хувийг эзэлж байгаа бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээнэ.
- 3.3.2 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
- 3.3.3 Сумын хэмжээнд ашиглагдаагүй, ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож дэд бүтэц, усан хангамжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 3.3.4 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар малчдын бүлэг, хоршоонд эзэмшүүлэх бодлогыг баримталж ажиллана.

**3.4. Газар тариалан**

- 3.4.1 Суманд үйл ажиллагаа явуулж буй мал амьтны тэжээлийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр дээд шатны байгууллагад уламжилна.
- 3.4.2 Газрын үржил шимийг зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлнэ.
- 3.4.3 Ургамал хамгаалалтын орчин үеийг арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.4.4 Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжин, сумын хүн амыг шинэ ургацын ногоогоор жилийн турш хангана.


**3.5. Мал аж ахуй**

- 3.5.1 Сумын хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.
- 3.5.2 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, малын үржил, мал эмнэлгийн үйлчилгээ хүртээмжийг чанартай болгож хяналтыг сайжруулна.
- 3.5.3 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малын вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.



**ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ БАЯНГОЛЧУУД**

- 4.1 Сумын нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй хийнэ.
- 4.2 Иргэд гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд сумын ИТХ шууд авч хэлэлцэх үйл ажиллагаа бий болгоно.
- 4.3 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэнэ.
- 4.4 Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд ажлын тайлангийн сонсгол хийх журамд шилжинэ.
- 4.5 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
- 4.6 Төсвийн зарцуулалт, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний хяналтыг нэмэгдүүлнэ.
- 4.7 Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоо, хяналтын боломжуудыг бодитоор хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 4.8 Сумаас зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод нээлттэй болгоно.



**ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН БАЯНГОЛЧУУД**

- 5.1 Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, иргэдийн амьдралын чанар, хүртээмжийг сайжруулна.
- 5.2 Соёлын биет болон биет бус өвийг аймаг, сумын баялагт тооцож холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, үрэгдэж гэмтэх, гадагш алдагдахаас хамгаална.
- 5.3 Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдэхэд анхаарч ажиллана.
- 5.4 Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгтэй мэдлэг мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.
- 5.5 Сумын үерийн хамгаалалтын даланг орон нутгийн хөгжлийн сангаар шинэчилнэ.
- 5.6 Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангуулна.
- 5.7 Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

**ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ**

- 6.1 Уур амьсгал, цаг уурын сөрөг нөлөөллийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.
- 6.2 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс дэмжүүлэх тал дээр хамтран ажиллана.
- 6.3 Газар ашиглалт, хот суурин, бүс нутгийн төлөвлөхдөө байгаль орчинд сөрөг нөлөөгүй, биологийн төрөл зүйлийн орчныг дордуулахгүй байх шалгуур үзүүлэлтийг баримтална.
- 6.4 Байгаль хамгаалах тухай хууль, журмыг зөрчсөн аж ахуйн нэгж иргэдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгана.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО



СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫГ 2020-2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ

АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ТОВЬЁГ



➤ **НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ**

- 1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол
- 1.2 Эрүүл мэндийн үйлчилгээ
- 1.3 Хүн амын өсөлт, хөгжил
- 1.4 Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт
- 1.5 Нийгмийн хамгаалал
- 1.6 Соёл, урлаг, спорт

➤ **ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**

- 2.1 Хямралыг боломж, боломжийг өсөлт
- 2.2 Өсөлтийн бодлого
- 2.3 Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа
- 2.4 Төсөв, санхүү, татварын бодлого
- 2.5 Хөдөлмөрийн зах зээл
- 2.6 Төрөлжилтийн бодлого
- 2.7 Үйлдвэрлэл
- 2.8 Дэд бүтэц, барилга
- 2.9 Барилгын салбар
- 2.10 Эрдэс баялгийн салбар
- 2.11 Аялал жуулчлал
- 2.12 Шинжлэх ухаан технологи, мэдээлэл, харилцаа
- 2.13 Эрчим хүч

➤ **ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ**

- 3.1 Орон нутгийн хөгжил
- 3.2 “Шинэ хөдөө” хөтөлбөр
- 3.3 Бэлчээр ашиглалт
- 3.4 Газар тариалан
- 3.5 Мал аж ахуй

➤ **ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ БАЯНГОЛЧУУД**

➤ **ТАВ. АЮУЛГҮЙ АМГАЛАН БАЯНГОЛЧУУД**

➤ **ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ**